



МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Содномын ЧИНЗОРИГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-52-06, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
http://www.parliament.mn

2016.12.28 № 6952  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай」

Монгол Улсын Үндсэн хуулийн 26.1, Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ дагуу УИХ-ын гишүүд бид “Хүн амын орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлж байна.

Уг хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

*S. Chinzorig*

С.ЧИНЗОРИГ





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Содномын ЧИНЗОРИГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-52-06, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
http://www.parliament.mn

2016.12.28 № 6951

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх

тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүд бид “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газрын саналыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.ЧИНЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЖАРГАЛТУЛГЫН ЭРДЭНЭБАТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Содномын ЧИНЗОРИГ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-52-06, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
http://www.parliament.mn

2016.12.22 № 6749


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүд бид "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар холбогдох материалын хамт Танд үүгээр хүргүүлж байна.

Хуулийн төслийн талаарх Засгийн газрын санал дүгнэлтийг зохих журмын дагуу ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

  
С.ЧИНЗОРИГ  
Л.ЭНХ-АМГАЛАН  
Д.ТОГТОХСҮРЭН  
Я.СОДБААТАР  
Ц.ЦОГЗОЛМАА  
Д.САРАНГЭРЭЛ  
Ё.БААТАРБИЛЭГ  
Н.АМАРЗАЯА  
М.ОЮУНЧИМЭГ



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2016 он /12/ дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар Х001/2286


Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
С.ЧИНЗОРИГ ТАНАА

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Та бүхний санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

005054

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлд:

“ХХИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын санаачлан боловсруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын санаачлан боловсруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд асуудлыг зарчмын хувьд дэмжиж байгааг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## **ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуульд өөрчлөлт оруулах болсон үндэслэл шаардлага:**

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2006 онд батлагдаж, 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж байгаа билээ. Энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т заасны дагуу албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох жилийн албан татварт 84.000 төгрөгийн хөнгөлөлт үзүүлж байна. Үүнийг сард шилжүүлж тооцвол ердөө 7 төгрөг байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт саарч, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхи суларснаас цалин хөлс, хөдөлмөрийн орлого төдийлөн нэмэгдсэнгүй, цаашид дорвитой нэмэгдэх хандлага ажиглагдахгүй байна. Эдийн засгийн хүндрэлийн улмаас аж ахуйн нэгжүүд сул зогсох, тодорхойгүй хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоож, ажиллагачдаа цалингүй амраах, цомхотгох, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулах хүртэл арга хэмжээ авч байна. Энэ байдал нь иргэдийн, ялангуяа бага орлоготой хэсгийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж, цалингийн зээлтэй хэсэг бүр хүнд байдалд орж байна.

Ийнхүү иргэдийн цалин хөлс, хөдөлмөрийн орлого нэмэгдэх боломж хомс байгаа нөхцөлд албан татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлэх замаар айл өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх шаардлага гарч байна.

МАН-аас УИХ-ын сонгуульд дэвшүүлэн оролцсон мөрийн хөтөлбөрийн 1.4.12 болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.13-д “Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ” гэж заасан нь энэхүү хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэс болж байна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:**

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд дараах өөрчлөлтүүдийг тусгана. Үүнд:

1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан албан татварын хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулж “Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт 84000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.” гэснийг “Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварын хөнгөлөлтийн хувь хэмжээ нь тухайн жилд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байна.” гэж өөрчлөн найруулна.

2. Энэ хуулийг 2018 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуулийн төсөлд тусгана.

**Гурав: Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагаврын талаар:**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар иргэд, ажиллагчдын орлого, цалин хөлснөөс төлөх албан татварт үзүүлэх татварын хөнгөлөлтийн хэмжээ нэмэгдэж, тэдгээрийн бодит орлого, худалдана авах чадвар нэмэгдэх болно.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2016 оны 4 дүгээр тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 240.000 төгрөг, цагт 1428 төгрөг 57 мөнгөөр тогтоож 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэсэн байна. Ийнхүү хувь хүний орлогын албан татварт үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байхаар хуульчлан тогтоовол татвар төлөгч иргэн жилд 240000 төгрөг, сард 20000 төгрөгийн хөнгөлөлт эдлэх болно.

Жилийн татварын хөнгөлөлтийн хэмжээг 2017 онд 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тооцоход 2018 онд улсын төсөвт хувь хүний орлогын албан татвараас төвлөрөх орлого 89.0 гаруй тэрбум төгрөгөөр буурах боловч иргэдийн бодит орлого нэг татвар төлөгчид сард 13000 төгрөг, жилд 156000 төгрөгөөр өснө. Нийгмийн даатгалын санд цалин хөлсөө мэдүүлж шимтгэл төлөгч 575.0 мянган иргэн байгаа бөгөөд татварын хөнгөлөлт эдэлсэн иргэдийн бодит орлого 89.0 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэх болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах талаар:**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудтай нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох хууль байхгүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧИД

## ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2006 онд батлагдсан бөгөөд 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж байгаа билээ. Энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т заасны дагуу албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох жилийн албан татварт 84.000 төгрөгийн хөнгөлөлт үзүүлж байна. Үүнийг сард шилжүүлж тооцвол ердөө 7 төгрөг байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт саарч, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхи суларснаас цалин хөлс, хөдөлмөрийн орлого төдийлөн нэмэгдсэнгүй, цаашид дорвитой нэмэгдэх хандлага ажиглагдахгүй байна. Энэ байдал нь иргэдийн, ялангуяа бага орлоготой хэсгийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа билээ.

Иймд хувь хүний орлогын албан татварт үзүүлэх хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах замаар бодит орлого, худалдан авах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2016 оны 4 дүгээр тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 240.000 төгрөг, цагт 1428 төгрөг 57 мөнгөөр тогтоож 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэсэн байна. Ийнхүү хувь хүний орлогын албан татварт үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байхаар хуульчлан тогтоовол татвар төлөгч иргэн жилд 240000 төгрөг, сард 20000 төгрөгийн хөнгөлөлт эдлэх болно.

Энэхүү хуулийн төсөл нь МАН-аас УИХ-ын сонгуульд дэвшүүлэн оролцсон мөрийн хөтөлбөрийн 1.4.12 болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.13 “Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ” гэсэн заалтад бүрэн нийцэж байгаа болно.

Хуулийн хэрэгжих хугацааг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

---oOo---



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ..... дүгээр  
сарын .....-ний өдөр

Улаанбаатар хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24 дүгээр зүйл. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх

24.1. Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварын хөнгөлөлтийн хувь хэмжээ нь тухайн жилд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ